



## **ИНД - 13**

Иргэний Нисэхийн Дүрэм

**Албадлагын дүрэм**

Иргэний нисэхийн ерөнхий газар

## **ДҮРМИЙН ТАЙЛБАР**

ИНД-13 нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- ИНД-ийг албадан хэрэгжүүлэх;
- ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх.

**Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-13-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-13, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл [www.mcaa.gov.mn](http://www.mcaa.gov.mn) веб сайтаас татаж авах боломжтой.**

## **Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

## **Өөрчлөлтийн түүх**

Анхны боловсруулалт

## **Хүчинтэй огноо**

2021 оны ... сарын ...

**Тэмдэглэл:** ИНД-13-ыг монгол, англи хэл дээр, 2020 оны 11 сарын “ICAO Model civil aviation regulations version 2.10”-д үндэслэн боловсруулсан болно.

## Гарчиг

<b>А Бүлэг - Ерөнхий зүйл</b> .....	<b>1</b>
13.1. Зорилго .....	1
13.3. Нэр томъёо болон товчлол .....	1
13.5. Иргэний нисэхийн эрх зүй .....	1
13.7. Нисэхийн баримт бичгийг бусдад шилжүүлэх (19.11) .....	1
<b>В Бүлэг - Албадлагын арга хэмжээ</b> .....	<b>2</b>
13.101. Албадлагын арга хэмжээний зорилго болон бодлого .....	2
13.103. Албадлагын арга хэмжээний зарчим .....	3
13.105. Захиргааны арга хэмжээ .....	4
13.107. Торгуулийн арга хэмжээ .....	4
13.109. Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ .....	5
13.111. Агаарын хөлгийн үйл ажиллагааг зогсоох .....	5
13.113. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил .....	6
<b>Хүснэгт 1. Торгуулийн арга хэмжээний шатлал</b> .....	<b>8</b>
<b>Хүснэгт 2. Албадлагын арга хэмжээ оногдуулах зөрчил</b> .....	<b>9</b>
I. Агаарын тээвэрлэгч, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөрчил .....	9
II. Агаарын тээвэрлэгчийн ажилтны зөрчил .....	14
III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил .....	18
IV. Хувь хүний үйлдсэн аюулгүй байдлын болон аюулгүйн хамгаалалтын зөрчил .....	27
V. Агаарын хөлгийн бүртгэлийн зөрчил .....	32
VI. Хувь хүн болон байгууллагын зөрчил .....	32
<b>С Бүлэг - ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх</b> .....	<b>33</b>
13.201. Ерөнхий зүйл .....	33
13.203. ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх хүсэлт .....	33
13.205. Хүсэлтийг хянан шийдвэрлэх .....	34
13.207. ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх шийдвэр .....	35
13.209. Шийдвэрт бусад сонирхогч талыг хамруулах .....	35

## Албадлагын дүрэм

### А Бүлэг - Ерөнхий зүйл

#### 13.1. Зорилго

Энэ Дүрмийн гол зорилго нь ICAO стандарт болон зөвлөмжийн суурь түвшинд үндэслэн боловсруулсан ИНД-ийн шаардлагын хэрэгжүүлэлтийг хангахад шаардлагатай албадлагын арга хэмжээг тогтооход оршино.

Энэ Дүрмээр дараах үйл ажиллагааны зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- (1) ИНД-ийг албадан хэрэгжүүлэх арга хэмжээ;
- (2) ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх.

#### 13.3. Нэр томьёо болон товчлол

Энэ Дүрэмтэй холбоотой нэр томьёо болон товчлол нь ИНД-ийн нэр томьёоны тайлбарт багтсан.

#### 13.5. Иргэний нисэхийн эрх зүй

(a) Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч бүр хууль, ИНД болон холбогдох зааврын шаардлагыг байнга дагаж мөрдөх үүрэгтэй.

(b) Агаарын тээвэрлэгч нь агаарын тээврийн үйл ажиллагаанд нислэгийн аюулгүй байдлыг өндөр түвшинд байнга хадгалан, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ИНД болон холбогдох зааврыг чанд мөрдөж, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг байнга авч ажиллах үүрэгтэй.

(c) Дарга хууль, ИНД болон холбогдох заавар зөрчсөн үйл ажиллагаа эрхлэгчийн үйлдэл бүрд энэ Дүрмийн дагуу үр дүнтэй, тохирсон албадлагын арга хэмжээ авах үүрэгтэй.

#### 13.7. Нисэхийн баримт бичгийг бусдад шилжүүлэх (19.11)

(a) Иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэхээр Даргын олгосон аливаа нисэхийн баримт бичгийг бусдад шилжүүлэхгүй.

(b) Шилжүүлсэн нисэхийн баримт бичиг нь түүнийг шилжүүлэн авсан этгээдэд аливаа эрхийг олгохгүй.

## **В Бүлэг - Албадлагын арга хэмжээ**

### **13.101. Албадлагын арга хэмжээний зорилго болон бодлого**

Болзошгүй осол, зөрчлийг аль болох эрт илрүүлэх, давтан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Дарга дараах албадлагын арга хэмжээний зохицуулалтыг тогтоох үүрэгтэй:

(a) Хууль, ИНД-ийн хэрэгжүүлэлтийн үр дүнг бататгах зорилгоор Дарга иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчид болон олон нийтийг албадлагын арга хэмжээтэй холбоотой мэдээлэл, гарын авлагаар хангах үүрэгтэй.

(b) Дарга ИНД-ийн хэрэгжилтийг бататгах үүргийг хуулиар хүлээсэн бөгөөд энэ үүрэг нь Даргын олгосон үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчид нэн тэргүүнд хамааралтай төдийгүй иргэний нисэхийн үйл ажиллагаанд оролцогч нэг бүрийн хүчин зүтгэл нэн чухал үүрэгтэй.

(c) Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангахын тулд хууль, дүрмийг зөвхөн хэрэгтэй үедээ хэрэгжүүлдэг байхаас илүүтэйгээр бүх нийтээр сайн дурын үндсэн дээр байнга даган мөрддөг байх нь онц чухал ач холбогдолтой.

(d) Энэ Дүрмээр тогтоосон албадлагын арга хэмжээ нь нислэгийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын бүх үйл ажиллагаанд нэгэн адил хамааралтай бөгөөд агаарын тээврийн үйл ажиллагаа, эсхүл агаарын хөлгийн засвар үйлчилгээ, эсхүл агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой гарсан зөрчил бүрд эрх бүхий байцаагч нь энэ Дүрмийн дагуу холбогдох албадлагын арга хэмжээг авахад шаардлагатай шинжлэн шалгах ажиллагааг гүйцэтгэн, тайлан гаргаж, Даргад мэдэгдэх үүрэгтэй.

(e) Агаарын тээвэрлэгч нь үйлчилгээгээ нислэгийн аюулгүй байдлын өндөр түвшинд гүйцэтгэн хууль, ИНД болон холбогдох зааврыг хэрэгжүүлэх үүргийг хуулиар хүлээсэн бөгөөд энэхүү хэрэгжүүлэлт нь ИНЕГ болон агаарын тээвэрлэгчийн хамтын хүчин чармайлтаас бүрдэнэ.

(f) Нислэгийн аюулгүй байдлын хяналт зохицуулалтын үзлэг шалгалтын үед олж тогтоосон, дахин давтагдаж байгаа зөрчлийг агаарын тээвэрлэгчид танилцуулахад Дарга онцгой анхаарал хандуулах үүрэгтэй. Агаарын тээвэрлэгч нь өөрийн үйл ажиллагаа, удирдлагын бүтэц болон холбогдох хөтөлбөрт удирдлагын дүгнэлт (management review) хийхдээ тухайн мэдээллийг ашиглах үүрэгтэй.

(g) Албадлагын арга хэмжээ нь тухайн зөрчилд тохирсон байх шаардлагатай бөгөөд Дарга арга хэмжээ нь зөрчил бүрд тохирсон болохыг бататгадаг байх үүрэгтэй.

**13.103. Албадлагын арга хэмжээний зарчим**

(a) Дарга энэ Дүрмийн дагуу албадлагын арга хэмжээг тодорхойлохдоо албадлагын бодлого болон зарчмыг баримтална.

(b) Албадлагын арга хэмжээнд шударга байх зарчмыг баримтлах ба энэ зарчмын амин чухал хэсэг нь энэхүү тогтолцоогоор дамжуулан албадлагын арга хэмжээний нэгдмэл, тууштай байдлыг хангахад оршино. Энэ зарчмыг хэрэгжүүлэхдээ ижил төстэй нөхцөл байдалд үйлдсэн зөрчилд ижил төрлийн албадлагын арга хэмжээ авна.

(c) Дарга тухайн зөрчлийг анх, эсхүл давтан үйлдсэн, санаатай, эсхүл санамсаргүй үйлдсэн, сайн дураар мэдээлсэн эсэх, тухайн хариуцагчийн зөрчлийн түүх зэрэг бодит нөхцөл байдлаас шалтгаалан албадлагын арга хэмжээг шат дараатай авах зарчмыг баримтална.

(d) Албадлагын арга хэмжээ нь дараах шатлал, зарчимтай байна:

- (1) урьдчилан сэргийлэх захиргааны арга хэмжээ нь сануулах, эсхүл анхааруулах арга хэмжээнээс бүрддэг байх;
- (2) торгуулийн арга хэмжээ нь албадлагын арга хэмжээний бодлогод нийцсэн байх ба тухайн зөрчлийг таслан зогсоох зорилготой бөгөөд гэмт этгээдэд эдийн засгийн хувьд мэдрэгдэхүйц хэмжээтэй байх;
- (3) дараах ноцтой зөрчлийг таслан зогсоох зорилгоор үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ нь тухайн гэмт этгээдийн үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгодог байх:
  - (i) бүртгэл, баримт бичгийг хуурамчаар үйлдэх;
  - (ii) үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчийн үл тоомсорлосон, **хайнга**, эсхүл хайхрамжгүй байдлаар зөрчсөн үйлдэл;
  - (iii) эрх бүхий байцаагчид **хариуцсан** талбай, байгууламж, бүртгэл, агаарын хөлөг болон түүний эд ангид үзлэг шалгалт хийхээр нэвтрэхэд саад болох, эсхүл татгалзах;
- (4) зөвхөн онц ноцтой тохиолдолд осол, ноцтой зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Дарга агаарын хөлгийн үйл ажиллагааг нэн даруй зогсоох арга хэмжээ авдаг байх.

(e) Зөрчлийг сайн дураар мэдээлэх нь тухайн зөрчилд оногдуулах албадлагын арга хэмжээг тогтооход хөнгөрүүлэх хүчин зүйл болно.

(f) Албадлагын арга хэмжээг авахдаа дан ганц **албадлагын арга хэмжээний тоон үзүүлэлтэд үндэслэхгүйгээр**, зөрчлийн сэдэл, нөхцөл байдал болон хариуцагчийн зөрчлийн түүх зэргийг шалган үзэж, шийдвэрлэнэ.

(g) Агаарын тээвэрлэгч нь нислэгийн аюулгүй байдлын өндөр стандартыг баримтлан, үйлчилгээгээ боломжит дээд түвшинд үзүүлэх үүрэгтэй.

(h) Агаарын тээвэрлэгч нь нислэгийн аюулгүй байдлын стандартад нийцсэн үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн эх үүсвэртэй байх үүрэгтэй бөгөөд аливаа санхүүгийн хүндрэлтэй байдал нь Хууль, ИНД болон холбогдох зааврыг зөрчих, эсхүл түүний шаардлагыг бууруулах үйлдлийг зөвтгөх шалтгаан болохгүй.

(i) Агаарын тээвэрлэгчийн нислэгийн аюулгүй байдлын стандартад хяналт тавих тогтолцоо нь бүртгэлийг үнэн зөв, нягт нямбай хөтлөх болон тайлан гаргах үйл ажиллагаанд суурилдаг тул Дарга баримт бичгийн зөрчлийг ноцтой зөрчилд тооцох үүрэгтэй.

### **13.105. Захиргааны арга хэмжээ**

(a) ИНД болон холбогдох заавар зөрчсөн, эсхүл зөрчсөн байж болзошгүй үйлдэлд захиргааны арга хэмжээ авах нь хангалттай гэж үзвэл, Дарга дараах захиргааны арга хэмжээний аль нэгийг авч болно:

- (1) тухайн зөрчил, эсхүл зөрчил байж болзошгүй үйлдлийг заасан баримт, мэдээллийг багтаасан “Сануулах мэдэгдэл”-ээр сануулга өгөх; эсхүл
- (2) тухайн зөрчил гаргагч хийсэн, эсхүл хийхийг зөвшөөрсөн шаардлагатай залруулах арга хэмжээг заасан, Даргын шийдвэрийг бататгасан “Залруулах мэдэгдэл”-ээр анхааруулга өгөх.

(b) Хэрэв тухайн этгээд нь засаж залруулах арга хэмжээг "Залруулах мэдэгдэл"-ийн дагуу бүрэн гүйцэд авч хэрэгжүүлээгүй бол, **13.109**-ийн дагуу үнэмлэх, гэрчилгээнд арга хэмжээг авч болно.

(c) Энэ зүйлийн дагуу авсан захиргааны арга хэмжээ нь тухайн этгээдийг хуулийн дагуу шийтгэл хүлээсэн гэж үзэх үндэслэл болохгүй.

### **13.107. Торгуулийн арга хэмжээ**

(a) Дарга энэ Дүрмийн дагуу Хууль, ИНД болон холбогдох заавар зөрчсөн дараах этгээдэд торгууль оногдуулахдаа Хүснэгт 1-д заасан торгуулийн арга хэмжээний шатлалыг баримтална:

- (1) хэв журам зөрчсөн зорчигч, хувь хүн, ерөнхий зориулалтын нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч, нисгэгч, инженер техникийн ажилтан болон агаарын тээвэрлэгчийн ажилтан;
- (2) зөвшөөрөгдсөн агаарын хөлгийн техник үйлчилгээний болон сургалтын байгууллага;
- (3) агаарын тээвэрлэгч, агаарын навигаци, аэродром болон аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ эрхлэгч.

(b) Дарга зөрчлийн нөхцөл байдлаас шалтгаалан Хүснэгт 2-т заасан торгуулийн, эсхүл үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээг дангаар нь, эсхүл хамтад нь авч болно.



**13.109. Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ**

(a) Дарга Хууль, ИНД болон холбогдох заавар зөрчсөн этгээдийн үнэмлэх, гэрчилгээг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох арга хэмжээг Хүснэгт 2-ын дагуу авч болно.

(b) ИНД-ийн дагуу олгосон аливаа үнэмлэх, гэрчилгээ эзэмшигч нь түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон үнэмлэх, гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй.

(c) Дарга энэ зүйлийн (a)-ийн дагуу үнэмлэх, гэрчилгээнд арга хэмжээ авсан тохиолдолд дараах үүрэгтэй:

(1) агаарын хөлөг, нисэхийн бүтээгдэхүүн, агаарын тээвэрлэгч, сургалтын болон техник үйлчилгээний байгууллага, эсхүл үнэмлэх, гэрчилгээ эзэмшдэг нисэхийн ажилтанд дахин үнэмлэх, гэрчилгээ олгохдоо ИНД-ийн дагуу дахин үзлэг, шалгалт хийх;

(2) хэрэв эрх бүхий байцаагчийн хийсэн үзлэг шалгалт, эсхүл бусад шинжлэн шалгах үйл ажиллагааны үр дүнд, нислэгийн аюулгүй байдал болон нийтийн ашиг сонирхлын шаардлагыг хангаагүй болох нь тогтоогдсон бол үнэмлэх, гэрчилгээнд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хязгаарлалт тогтоох, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох.

(d) Агаарын тээврийн үйл ажиллагаанд нислэгийн аюулгүй байдлын шаардлагаар яаралтай арга хэмжээ авахаас бусад тохиолдолд, албадлагын арга хэмжээний талаар Дарга эцсийн шийдвэр гаргахаас өмнө энэ Дүрмийн дагуу үнэмлэх, гэрчилгээнд нь хязгаарлалт тогтоох, эсхүл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох арга хэмжээ авахуулахгүй байх шалтгаанаа тайлбарлах боломжийг тухайн этгээдэд олгох үүрэгтэй.

(e) Дарга өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд, үнэмлэх, гэрчилгээндээ арга хэмжээ авахуулсан этгээд нь тухайн үнэмлэх, гэрчилгээгээ сэргээлгэх хүсэлтийг дараах хугацаанд гаргах эрхгүй:

(1) хүчингүй болгосон өдрөөс 1 жил;

(2) түдгэлзүүлсэн тухайн хугацаанд.

**13.111. Агаарын хөлгийн үйл ажиллагааг зогсоох**

(a) Үйл ажиллагаа эрхлэгч нь зөрчилтэй холбоотойгоор өмнө нь Хууль болон энэ Дүрмийн дагуу торгуулийн, эсхүл гэрчилгээнд авах арга хэмжээ авахуулж байсан, эсхүл авахуулах нөхцөлд орж байсан бол Дарга зөвхөн тухайн нислэгийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хойшлуулшгүй онц ноцтой тохиолдолд агаарын хөлгийн үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч болно.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн агаарын хөлгийн үйл ажиллагааг зогсооход хүргэсэн нөхцөл байдлыг бүрэн залруулсан болохыг эрх бүхий байцаагч үзлэг шалгалтаар тогтоосон тохиолдолд Дарга агаарын хөлгийн үйл ажиллагааг сэргээж болно.

**13.113. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчил**

- (a) Хууль, ИНД болон холбогдох зааврыг мэдсээр байж, санаатайгаар зөрчин, хүний амь нас, эрүүл мэнд, эсхүл өмч хөрөнгөд хохирол учруулсан этгээдийн хууль бус үйлдэлд эрх бүхий байгууллага хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- (b) Дарга тухайн зөрчил нь Эрүүгийн хууль, эсхүл бусад хууль зөрчсөн гэж үзэх үндэслэл байгаа бол эрх бүхий байгууллагад яаралтай мэдэгдэх үүрэгтэй.
- (c) Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт үйлдэлд Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- (d) Дараах зөрчлүүд нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх зөрчилд багтана:
- (1) Хууль, ИНД-ийн дагуу олгодог аливаа үнэмлэх, гэрчилгээг мэдсээр байж, санаатайгаар үйлдэх, дурайлгах, өөрчлөх, эсхүл хуурамчаар үйлдэх, эсхүл хуурамч үнэмлэх, гэрчилгээг мэдсээр байж ашиглах, эсхүл ашиглахыг завдах ба мэдсээр байж, санаатайгаар үзүүлэх, эсхүл үзүүлэхийг завдах;
  - (2) нислэгийн үйл ажиллагаанд дараах байдлаар хөндлөнгөөс оролцох:
    - (i) нислэгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох зорилгоор ИНД-ийн дагуу байрлуулах гэрэл, эсхүл дохио, эсхүл нисэх буудал, навигацийн туслах хэрэгсэл, бусад төхөөрөмжтэй холбоотой гэрэл, дохиог төөрөгдүүлэх зорилгоор байрлуулах, эсхүл хэрэглэх, эсхүл Даргаас зохих ёсоор анхааруулсаар байхад санаатайгаар гэрэл, эсхүл дохиог үргэлжлүүлэн хэрэглэх;
    - (ii) гэрэл, эсхүл дохиог мэдсээр байж зайлуулах, унтраах, эсхүл үйл ажиллагаанд нь нөлөөлөх;
  - (3) үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл түүний ажилтан Хууль, ИНД-ийн дагуу Даргад мэдээлэх шаардлагатай бүртгэл, тайланг мэдсээр байж, санаатайгаар гаргаагүй, эсхүл гаргахаас татгалзах; эсхүл Даргын тогтоосон, эсхүл баталсан аргачлал, арга хэлбэрээр хадгалаагүй, эсхүл хамгаалах арга хэмжээ аваагүй, эсхүл авахаас татгалзах; эсхүл гуйвуулах, эсхүл өөрчлөх; эсхүл хуурамч тайлан гаргах, хадгалах;
  - (4) Дарга Хууль, ИНД-ийн дагуу шаардсан баримт бичиг, нотлох баримтыг гаргаж өгөхөөс зайлсхийх, эсхүл мэдүүлэг, шалгах тест өгөх, асуултад хариулах зэргээс татгалзах;
  - (5) агаарын хөлгийг булаан авах, эсхүл булаан авахыг завдах;
  - (6) нисэх багийн гишүүдийн үйл ажиллагаанд дараах байдлаар хөндлөнгөөс оролцох:
    - (i) ажил үүрэг гүйцэтгэх чадварыг нь бууруулах;
    - (ii) хүч хэрэглэх, сүрдүүлэх, эсхүл заналхийлэх;
    - (iii) бусдын амь нас, эрүүл мэндийг хохироох, эсхүл аюултай зэвсэг хэрэглэх;
  - (7) Агаарын хөлгийн бүхээгт аюултай, эсхүл үхэлд хүргэх чадвартай зэвсгийг нислэгийн үед авч хэрэглэх боломжтойгоор нууж авч орох, эсхүл авч орохыг завдах;
  - (8) Агаарын хөлөгт бөмбөг, бусад тэсрэх, эсхүл шатах хэрэгслийг байрлуулах, эсхүл байрлуулахыг завдах;
  - (9) нислэгийн аюулгүй байдал болон агаарын хөлгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, эсхүл оролцохыг завдах, бусдын амь нас, эрүүл

- мэндэд аюултай, санаатай болон хайхрамжгүй үл тоомсорлосон байдлаар агаарын хөлгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох;
- (10) энэ зүйлийн (5) - (9)-д заасан гэмт хэрэгт тооцогдох үйлдэл хийхийг завдах, эсхүл хийхийг завдаж байгаа талаарх мэдээллийг хуурамч байж болохыг мэдсээр байж, худал мэдээлэл өгөх, эсхүл дамжуулах, эсхүл бусдыг мэдээлэл өгөх, эсхүл дамжуулах шалтгаан болох, бусдын амь нас, эрүүл мэндэд аюултай, санаатай болон гэмт хэргийн сэдэлтэй, эсхүл хайхрамжгүй үл тоомсорлосон байдлаар хуурамч мэдээлэл өгөх;
- (11) мэдсээр байж осолд өртсөн агаарын хөлгийн аль нэг эд ангийг салгаж авах, осолд өртсөн агаарын хөлгийн эд анги, эсхүл ослын үед агаарын хөлгийн бүхээгт байсан аливаа эд зүйлийг зөвшөөрөлгүй салгаж авах, нуух, авч үлдэх, эсхүл хадгалах;
- (12) Хууль, ИНД-ийн шаардлагыг мэдсээр байж санаатайгаар агаарын тээврийн үйл ажиллагаанд агаарын тээвэрлэгчид аюултай барааг тээвэрлэлтэд хүлээлгэн өгөх, эсхүл өгөх шалтгаан болох, эсхүл хэрэв аливаа этгээд агаарын тээврийн үйл ажиллагаанд хайхрамжгүйгээр ачаа, тээш, эсхүл эд зүйлсийг Чикагогийн конвенцийн Хавсралт 18-ын шаардлага болон ИCAO-гийн Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх Техникийн Зааварчилгааг зөрчин тээвэрлэх шалтгаан болох.

**Хүснэгт 1. Торгуулийн арга хэмжээний шатлал**

Энэ Дүрмийн дагуу тодорхой зөрчилд оногдуулах торгуулийн арга хэмжээний доод, дунд болон дээд шатлалыг Хүснэгт 1-д заасан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дахин нэмэгдүүлсэн нэгжээр тогтооно.

Зөрчил гаргасан этгээд	Торгуулийн арга хэмжээний шатлал (хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дахин нэмэгдүүлсэн)
Агаарын тээвэрлэгч, Аэродром болон Аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ эрхлэгч	<p>Дээд: 50 - 100 Дунд: 25 - 50 Доод: 15 - 25</p>
Агаарын тээвэрлэгчийн ажилтан	<p>Дээд: 6 - 12 Дунд: 3 - 6 Доод: 1 - 3</p>
Ерөнхий зориулалтын нисэх - Өмчлөгч, Үйл ажиллагаа эрхлэгч, Нисгэгч болон Инженер техникийн ажилтан, Хэв журам зөрчсөн зорчигч, хувь хүн	<p>Дээд: 4 - 10 Дунд: 2 - 4 Доод: 1 - 2</p>
Зөвшөөрөгдсөн агаарын хөлгийн техник үйлчилгээний болон сургалтын байгууллага	<p>Дээд: 20 - 50 Дунд: 10 - 20 Доод: 5 - 10</p>

**Тайлбар:** Хүснэгт 1-д заасан хувь хүн, хуулийн этгээдийн торгуулийн арга хэмжээний шатлалыг 2020 оны 11 сарын “ICAO Model civil aviation regulations version 2.10”-д үндэслэн тогтоосон.

## Хүснэгт 2. Албадлагын арга хэмжээ оногдуулах зөрчил

Хууль, ИНД-ийн зөрчилд оногдуулах торгууль болон үнэмлэх, гэрчилгээнд авах албадлагын арга хэмжээг тодорхойлох зааварчилгааг Хүснэгт 2-д заасан болно.

### I. Агаарын тээвэрлэгч, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөрчил

I. Агаарын тээвэрлэгч, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>1. Техник үйлчилгээний заавар</b>		
(a) Зааврыг хүчинтэй байдлаар хадгалаагүй	Дунд	7 хүртэл хоногоор түдгэлзүүлэх
(b) Зааварт холбогдох журам болон зааварчилгааг тусгаагүй	Дундаас Дээд	-
(c) Зааврыг холбогдох ажилтанд түгээгээгүй	Доодоос Дунд	-
(d) Шаардлагатай төхөөрөмжгүй агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэх	Дундаас Дээд	7 хүртэл хоногоор түдгэлзүүлэх
<b>2. НТЧ-ын Удирдамжийг хэрэгжүүлээгүй</b>	Дундаас Дээд	-
<b>3. Үйл ажиллагааны тодорхойлолт</b>		
(a) Үзлэг болон их засварын цагийн хязгаарлалтыг баримтлаагүй	Дунд	7 хүртэл хоногоор түдгэлзүүлэх
(b) Техникийн шаардлага хангаагүй, үйл ажиллагааны тодорхойлолтоос зөрүүтэй үйл ажиллагаа гүйцэтгэх	Доод	-
(c) Нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, эсхүл бодитоор нөлөөлж болох, үйл ажиллагааны тодорхойлолтоос зөрүүтэй үйл ажиллагаа гүйцэтгэх	Дундаас Дээд	-
<b>4. Байгууламж, төхөөрөмжийн үзлэг, засвар болон техник үйлчилгээг зохих ёсоор хийгээгүй</b>	Дээд	Байгууламж, төхөөрөмжийн техник үйлчилгээг зохих ёсоор хийх хүртэл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
<b>5. Техник үйлчилгээ болон үзлэг, шалгалт хийх байгууллагыг зохих ёсоор ажиллуулж чадаагүй, эсхүл дээрх байгууллагаар хангаж чадаагүй</b>	Дээд	Техник үйлчилгээг өөр байгууллагаар хийлгэх хүртэл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох

I. Агаарын тээвэрлэгч, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>6. Сургалтын хөтөлбөр</b>		
(a) Тохирсон сургалтын хөтөлбөргүй, эсхүл түүнийг хэрэгжүүлээгүй	Дээд	хэрэгжүүлэлтийг харуулах хүртэл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(b) Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй	Дундаас Дээд	-
(c) Ажилтнаа зохих ёсоор сургаагүй	Дундаас Дээд	-
<b>7. Техник үйлчилгээний, эсхүл агаарын хөлгийн баримт бичиг</b>		
(a) Бүрэн бус баримт бичигтэй, эсхүл гарын үсэг зуралгүйгээр ашиглалтад шилжүүлэх	Доодоос Дээд	-
(b) Техник үйлчилгээний дараа агаарын хөлгийн өгөгдлийг шинэчлээгүй	Дундаас Дээд	-
<b>8. Техник үйлчилгээний гүйцэтгэл</b>		
(a) Эрх олгогдоогүй этгээдээр гүйцэтгүүлэх	Дээд	-
(b) Техник үйлчилгээг хийгээгүй, эсхүл зохих ёсоор хийгээгүй	Дундаас Дээд	-
<b>9. Засварын дараа агаарын хөлгийн өгөгдлийг шинэчлээгүй</b>	Дундаас Дээд	-
<b>10. Бүртгэл болон тайлан</b>		
(a) Техникийн дутагдлын нэгдсэн тайланг үнэн зөв гаргаагүй	Дундаас Дээд	-
(b) Том хэмжээний модификаци, эсхүл засварын тайланг гаргаагүй	Дундаас Дээд	тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(c) Техникийн найдвартай ажиллагааны тайланг үнэн зөв гаргаагүй	Дундаас Дээд	-
(d) Техник үйлчилгээний тайлан бүртгэлийг хадгалаагүй	Дээд	7 хоног түдгэлзүүлэх ба түүний дараа тухайн агаарын хөлгийг нислэгт тэнцэх нөхцөлтэй болох хүртэл түдгэлзүүлэх
(e) Агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэрт шаардлагатай бичилт хийгээгүй	Дундаас Дээд	-

I. Агаарын тээвэрлэгч, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(f) Нисгэгчийн бүртгэлийг шалгалтад бэлэн байлгаагүй	Дундаас Дээд	тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(g) Ачаалалтын манифестийг шалгалтад бэлэн байлгаагүй	Дундаас Дээд	тодорхойгүй хугацаагаар түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(h) Нислэгийн үед радио холбоог тогтмол сонсож хяналт тавиагүй	Дундаас Дээд	-
(i) Санаатай зөрчил - санаатайгаар техник үйлчилгээний тайланг, эсхүл бичилтийг хуурамчаар үйлдэх, эсхүл залилан хийх зорилгоор бичилт хийх, өөрчлөх, эсхүл , нөхөн үйлдэх	-	хүчингүй болгох
(j) Бусад санаатай зөрчил	-	180 хоног түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
<b>11. НТЧ-гүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх</b>		
(a) Маягийн гэрчилгээний техникийн өгөгдлийн үл тохирол, гэхдээ нислэгийн аюулгүй байдалд болзошгүй байдлаар, эсхүл бодитоор нөлөөлөхгүй	Доод	-
(b) Нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болзошгүй үл тохирол	Дундаас Дээд	-
(c) Шаардлагатай төхөөрөмжгүй агаарын хөлгийг ашиглалтад шилжүүлэх	Дундаас Дээд	7 хүртэл хоногоор түдгэлзүүлэх
<b>12. Зорчигч тээвэрлэхтэй холбоотой тусгай заалт</b>		
(a) Хэт согтсон этгээдийг агаарын хөлөгт суулгах, эсхүл согтууруулах ундаагаар үйлчлэх	Дээд	-
(b) Зорчигчдод аюулгүйн зааварчилгаа өгөөгүй	Дундаас Дээд	-
(c) Зорчигч бүр суудалдаа сууж, суудлын даруулгаа хийснийг шалгаагүй	Дээд	-
(d) Ажиллагаагүй нийтэд зарлан мэдээлэх системтэй үйл ажиллагаа гүйцэтгэх	Дээд	-
(e) Гар тээшийг зохих ёсоор байрлуулаагүй	Дунд	-

I. Агаарын тээвэрлэгч, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>13. Нислэгийн үед шалгалт хийх эрх бүхий байцаагчид нислэгийн бүхээгт суудал гаргаж өгөөгүй</b>	Дээд	-
<b>14. Нисэх багийн гишүүдтэй холбоотой тусгай заалт</b>		
(a) Мэргэшээгүй нисэх багийн гишүүн ашиглах	Дээд	-
(b) Хугацаа дууссан ЭМГ-тэй нисэх багийн гишүүн ашиглах	Доодоос Дунд	-
(c) Нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн зөрчил	Дунд	-
<b>15. Нислэгт гаргах болон ашиглалтад шилжүүлэхтэй холбоотой зөрчил</b>	Дундаас Дээд	-
<b>16. Бусад зүйлс</b>		
(a) Агаарын хөлгийг зохих ёсоор ашиглалтад шилжүүлээгүй	Дээд	-
(b) Агаарын тээвэрлэгч мэдсээр байж тусгай хяналттай бодисыг хууль бусаар тээвэрлэх, жишээ нь: удирдах албан тушаалтан мэдэж байсан	-	хүчингүй болгох
(c) Нисэх багийн гишүүдээс бусад мэргэшээгүй ажилтныг ашиглах	Дээд	-
<b>17. Аюулгүйн хамгаалалттай холбоотой зөрчил</b>		
(a) Зорчигч бүрд, эсхүл тээшинд аюулгүй үзлэгийг зохих ёсоор хийгээгүй	Дээд	-
(b) Аэродромын үйл ажиллагааны бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэх	Дээд	-
(c) Зэвсэг, шатах болон бусад аюултай хэрэгслийг илрүүлж чадаагүй үйлдлийг багтаасан, агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлагыг биелүүлээгүй	Дээд	-
(d) Удирдах ажилтан техник үйлчилгээний бүртгэл/тайланг хуурамчаар үйлдэхийг албадан шаардах, хүлээн зөвшөөрөх, эсхүл дэмжих	-	хүчингүй болгох



I. Агаарын тээвэрлэгч, аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(e) Ажилтны бүртгэлийг санаатайгаар хөтлөөгүй	Дээд	-
(f) Сорилт шалгалт хийгээгүй	Дунд	-
(g) Шалгах төхөөрөмж болон аюулгүйн үзлэгийн ажилтанд сорилт шалгалт хийгээгүй	Дунд	-
(h) Зохих ёсоор сургалтад хамрагдаагүй	Дунд	-
(i) Санаандгүй байдлаар аюулгүйн үзлэгийн ажилтны сорилт шалгалтын бүртгэлийг хөтлөөгүй	Доодоос Дунд	-
(j) Шалгах хэрэгсэл буруу ашиглах	Доод	-
(k) Биеийн байцаалт, нэвтрэх үнэмлэхний журмыг мөрдөөгүй	Доодоос Дунд	-
(l) Биеийн байцаалтыг шалгах/ хянах тогтолцоог хэрэгжүүлээгүй	Дээд	-
(m) Эх сурвалжийг тодорхойлох шалгалт хийгээгүй	Доодоос Дунд	-
(n) Сорилын биетийг илрүүлээгүй	Дээд	-
(o) Хүчинтэй аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн шаардлагыг биелүүлээгүй	Дээд	-
(p) Нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажилтан хариу арга хэмжээг цаг тухайд нь аваагүй	Дээд	-

**II. Агаарын тээвэрлэгчийн ажилтны зөрчил**

II. Агаарын тээвэрлэгчийн ажилтны зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>1. Үзлэг, шалгалтыг багтаасан техник үйлчилгээ</b>		
(a) Үнэмлэх, зэрэглэл, эсхүл зөвшөөрөлгүй техник үйлчилгээ хийх	Дээд	-
(b) Эрх, хязгаарлалтыг хэтрүүлэн техник үйлчилгээ хийх	-	30 - 45 хоног түдгэлзүүлэх
(c) Техник үйлчилгээг зохих ёсоор хийгээгүй	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
<b>2. Үзлэг шалгалтын ажилтан</b>		
(a) Заавал хийх шаардлагатай үзлэг шалгалтыг хийгээгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(b) Үзлэг шалгалтыг зохих ёсоор хийгээгүй	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
(c) Агаарын хөлгийг зохих ёсоор ашиглалтад шилжүүлээгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(d) Агаарын хөлгийг шаардлагатай төхөөрөмжгүйгээр ашиглалтад шилжүүлэх	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
<b>3. Бүртгэл болон тайлан</b>		
(a) Агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэрт бичилт хийгээгүй	-	15 - 60 хоног түдгэлзүүлэх
(b) Ажлын хуудсанд бичилт хийгээгүй	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх
(c) Бусад техник үйлчилгээний бүртгэлийн бичилт хийгээгүй	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх
(d) Гүйцэтгэсэн ажил, үзлэг шалгалтын дараа гарын үсэг зураагүй	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх
(e) Ашиглалтад шилжүүлэх зөвшөөрлийг бүрдүүлээгүй, эсхүл гарын үсэг зураагүй	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх
(f) Санаатайгаар бүртгэл, эсхүл тайланг хуурамчаар үйлдэх	-	хүчингүй болгох
<b>4. Нислэгийн өмнө</b>		
(a) Нислэгийн өмнөх үзлэгт нислэгийн бүхээгийн шалгах хуудас ашиглаагүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх

II. Агаарын тээвэрлэгчийн ажилтны зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(b) Агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэр, ачааллын манифест, цаг агаарын мэдээ зэргийг шалгаагүй	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(c) Заавал хийх шаардлагатай үзлэг шалгалтыг хийгээгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(d) Агаарын хөлөгт үзлэг хийгээгүй, эсхүл үзлэгийг зохих ёсоор хийгээгүй	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх
(e) Зорчигч бүрийн суудал болон суудлын даруулгыг шалгаагүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
<b>5. Явгалах</b>		
(a) Явгалах зөвшөөрөл, эсхүл зааварчилгааг мөрдөөгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(b) Явгалж байхдаа мөргөлдөх	-	30 - 180 хоног түдгэлзүүлэх
(c) Хөдөлгүүрийн тийрэлтэд хийн урсгалаар цохилт өгөх	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
(d) Зорчигч суугаагүй үед явгалах	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(e) ХБЗ, явгалах зам, эсхүл апроноос гадуур явгалах	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
<b>6. Хөөрөлт үйлдэх</b>		
(a) Зөвшөөрөл, эсхүл зааварчилгаа зөрчиж хөөрөлт үйлдэх	-	60 - 120 хоног түдгэлзүүлэх
(b) Цаг агаарын минима-гаас доогуур үед хөөрөлт үйлдэх	-	60 - 120 хоног түдгэлзүүлэх
(c) Хэт ачаалалттай агаарын хөлгөөр хөөрөлт үйлдэх (MCTOW-г хэтрүүлэн)	-	60 - 120 хоног түдгэлзүүлэх
<b>7. Нислэгийн замд</b>		
(a) Зөвшөөрөл, эсхүл зааварчилгаанаас хазайх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(b) Үүлэн дотор VFR-аар нислэг үйлдэх	-	90 хоног түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(c) НТЧ-гүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх	-	30 - 180 хоног түдгэлзүүлэх
(d) Нислэгийн бүхээгээс зөвшөөрөлгүй гарах	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх

II. Агаарын тээвэрлэгчийн ажилтны зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(e) Хязгаарлалттай бүс, эсхүл цэргийн үйл ажиллагааны бүс, эсхүл радио нэвтрүүлэг шаардлагатай зоон болон зөвшөөрөл шаардлагатай А, С, D-ангиллын хяналттай агаарын зайд НХУ-ын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа гүйцэтгэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(f) Шаардлагатай төхөөрөмжгүйгээр үйл ажиллагаа гүйцэтгэх	-	15 - 120 хоног түдгэлзүүлэх
(g) Түлшний буруу зохицуулалт хийх /түлшгүй болох	-	30 - 150 хоног түдгэлзүүлэх
(h) NOTAM зөрчиж үйл ажиллагаа гүйцэтгэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(i) Зөвшөөрөлгүй этгээд жолоодлогод оролцох	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
<b>8. Ойртолтоос буулт үйлдэх</b>		
(a) Аэродромын бүсэд зөвшөөрөл, эсхүл зааварчилгаанаас хазайх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(b) Цаг агаарын минима-гаас доогуур үед ойртолт үйлдэх	-	60 - 120 хоног түдгэлзүүлэх
(c) Аэродромын хөдөлгөөний бүсэд хурдны хязгаарлалт хэтрүүлэх	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
<b>9. Буулт үйлдэх</b>		
(a) Буруу аэродромд буулт үйлдэх	-	90 - 180 хоног түдгэлзүүлэх
(b) Хэрэглэлийн ойртолтын журмаас хазайх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(c) Хэтэрсэн жинтэй буулт үйлдэх / Overweight landing (хэвийн бус нөхцлөөс бусад)	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(d) Хатуу буулт үйлдэх / Hard landing	-	15 - 60 хоног түдгэлзүүлэх
(e) Богино, эсхүл урт буулт үйлдэх / Short or long landing	-	30 - 180 хоног түдгэлзүүлэх
(f) Дугуй хураалттай буулт үйлдэх / Wheels up landing	-	10 - 90 хоног түдгэлзүүлэх
(g) ХБЗ ашиглалтын зааврыг мөрдөөгүй	-	15 хоног түдгэлзүүлэх
(h) Зөвшөөрөл, эсхүл зааварчилгаанаас хазайх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх

II. Агаарын тээвэрлэгчийн ажилтны зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>10. Нислэгийн бүхээгт зөвшөөрөлгүй этгээдийг нэвтрүүлэх</b>	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
<b>11. Нислэгийн бүхээгийн хаалгыг хааж, түгжээгүй</b>	Дээд	30 хоног түдгэлзүүлэх
<b>12. Согтууруулах, эсхүл бусад сэтгэцэд нөлөөлөх бодисын нөлөөнд байхдаа, эсхүл 12 цагийн дотор согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ нисэх багийн гишүүний үүрэг гүйцэтгэх, эсхүл гүйцэтгэхийг завдах</b>	-	нэн даруй хүчингүй болгох
<b>13. Нислэгийн бүхээгт эрх бүхий байцаагчийг оруулахаас татгалзах</b>	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
<b>14. Нислэгийн болон үүрэг гүйцэтгэх цагийн хязгаарлалтыг зөрчих</b>	-	15 - 90 хоног түдгэлзүүлэх
<b>15. Шаардлагатай үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлгүй үйл ажиллагаа эрхлэх</b>		
(a) ЭМГ-гүй	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(b) Маягийн зэрэглэлгүй	-	180 хоног түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(c) Шугамын, эсхүл мэргэжлийн ур чадварын дүгнэлт хийлгээгүй	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(d) Туршлага хадгалах шаардлага хангаагүй, анхан шатны, эсхүл давтан сургалтад хамрагдаагүй	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(e) Хүчинтэй ЭМГ, үнэмлэх, эсхүл зөвшөөрөл биедээ авч яваагүй	Доодоос Дунд	
(f) Хөдөлмөрийн чадвараа алдсанаа мэдсээр байж үйл ажиллагаанд оролцох	-	хүчингүй болгох
(g) Эрүүл мэндийн шаардлага хангаагүй, эсхүл ЭМГ авах хүсэлт нь хойшлуулагдсан үед хүчинтэй ЭМГ-гүй үйл ажиллагаанд оролцох	-	хүчингүй болгох
<b>16. Зааврыг хүчинтэй байдлаар хадгалаагүй</b>	Доод	30 - 90 хоног түдгэлзүүлэх

**III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил**

III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>1. Багийн гишүүдээс бусад өмчлөгч болон үйл ажиллагаа эрхлэгч</b>		
(a) НТЧ-ын Удирдамжийг биелүүлээгүй	Дундаас Дээд	-
(b) Шаардлагатай техник үйлчилгээг багтаасан засвар үйлчилгээг хийгээгүй, эсхүл зохих ёсоор хийгээгүй	Дундаас Дээд	-
(c) Агаарын хөлгийн бүртгэлийн дэвтэрт холбогдох бичилтийг хийгээгүй	Доодоос Дунд	-
(d) Жилийн, 100 цагийн, эсхүл хэсэгчилсэн үзлэг шалгалтын хугацааг хэтрүүлэн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх	Доодоос Дунд	-
(e) НТЧ-гүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх	Дундаас Дээд	-
(f) Санаатайгаар техник үйлчилгээний тайлан, бүртгэлийг хуурамчаар үйлдэх, эсхүл залилан хийх зорилгоор нөхөн үйлдэх, эсхүл өөрчлөх	Дээд	хүчингүй болгох
<b>2. АХТҮБ</b>		
(a) Засвар, техник үйлчилгээ болон үзлэг шалгалт хийх бололцоогоор хангаагүй	Дундаас Дээд	хэрэгжүүлэлт хангагдах хүртэл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(b) Техник үйлчилгээний байгууллагыг эрх нь олгогдсон ажлыг гүйцэтгэх, хянах болон үзлэг шалгалт хийхэд шаардлагатай хангалттай тооны ажилтнаар хангаагүй	Дээд	шаардлагатай ажилтнаар хангах хүртэл 7 хоног түдгэлзүүлэх ба түүний дараа хэрэгжүүлэх хүртэл түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(c) Тухайн ажлын багтаамж шаардсан хангалттай тооны мэргэшсэн ажилтнаар хангаагүй	Дээд	7 хүртэл хоногоор түдгэлзүүлэх ба түүний дараа гэрчилгээ эзэмшигч хангалттай тооны мэргэшсэн ажилтантай болох хүртэл түдгэлзүүлэх

III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(d) Хяналт шалгалт хийх болон үзлэг хийх ажилтны бүртгэлийг хөтлөөгүй	Дундаас Дээд	-
(e) Техникийн үзүүлэлтийн бүртгэл болон тайланг хөтлөөгүй	Дундаас Дээд	-
(f) Тогтоосон хугацаанд бүх үзлэг, шалгалтын төхөөрөмжид зөв зүйтэй тохируулга хийсэн болохыг бататгаагүй	Доодоос Дээд	-
(g) Гүйцэтгэсэн ажлын тодорхойлолтыг үнэн зөв гаргаагүй	Доодоос Дээд	-
(h) Инженер техникийн ажилтан бүртгэлийн дэвтэрт бичилт, эсхүл бүртгэл хийгээгүй	Дундаас Дээд	-
(i) Ашиглалтад шилжүүлэх зөвшөөрлийг бүрдүүлээгүй, эсхүл гарын үсэг зураагүй	Доодоос Дунд	-
(j) Мэргэшсэн, гэрчилгээжүүлэх ажилтнаас өөр этгээд гүйцэтгэсэн ажилд үзлэг шалгалт хийж, ашиглалтад шилжүүлэх	Дээд	30 хоног түдгэлзүүлэх
(k) Хангалттай чанарын хяналтыг тогтоох зорилгоор хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлээгүй	Дунд	30 хоног түдгэлзүүлэх ба түүний дараа тохирох үзлэг, шалгалт хийх систем тогтоох хүртэл түдгэлзүүлэх
(l) Шаардлагатай техникийн өгөгдөл, төхөөрөмж, эсхүл байгууламжийг ашиглахгүйгээр, тухайн байгууллагад эрх нь олгогдсон нисэхийн бүтээгдэхүүнд үйлчилгээ, эсхүл модификаци хийх	Дээд	30 хоног түдгэлзүүлэх
(m) Техник үйлчилгээ, засвар, модификаци, эсхүл заавал хийх шаардлагатай үзлэг шалгалтыг хийгээгүй, эсхүл зохих ёсоор хийгээгүй	Дундаас Дээд	30 хоног түдгэлзүүлэх
(n) Тухайн байгууллагад эрх нь олгогдоогүй хүчилсэн бүтэц, хүчний төхөөрөмж, сэнс, хэрэглэл, радио, эсхүл туслах тоноглолд техник үйлчилгээ, эсхүл модификаци хийх	Дээд	түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох

III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(о) Гэмтэл, эсхүл НТЧ-гүй байдлыг Даргад цаг тухайд нь мэдээлээгүй	Дундаас Дээд	-
(р) Ажлын байр болон байгууламжийн шаардлагыг хангаагүй	Дунд	ажлын байрны болон байгууламжийн шаардлагыг хангах хүртэл түдгэлзүүлэх
(q) Бичгээр урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр ажлын байр, эсхүл байгууламжийн байрлалыг өөрчлөх	Дунд	зөвшөөрөл олгох хүртэл түдгэлзүүлэх
(r) Зөвшөөрөгдсөн ТҮБ-ын гэрчилгээгүй техник үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Дээд	-
(s) Эрх бүхий байцаагчийг үзлэг шалгалт хийх бололцоогоор хангаагүй	Дээд	эрх бүхий байцаагчид үзлэг хийх нөхцөл бүрдүүлэх хүртэл түдгэлзүүлэхээс
<b>3. Ерөнхий зориулалтын нисэхийн инженер техникийн ажилтан</b>		
(a) Үндсэн засвар, эсхүл том хэмжээний модификаци хийсний дараа агаарын хөлгийн өгөгдлийг шинэчлээгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(b) Засвар үйлчилгээг хийгээгүй, эсхүл зохих ёсоор хийгээгүй	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
(c) Инженер техникийн ажилтан үзлэг шалгалтыг зохих ёсоор хийгээгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(d) Инженер техникийн ажилтан үзлэг шалгалтын бүртгэлийг хөтлөөгүй	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх
(e) Үзлэг шалгалт хийх эрхтэй ажилтан үзлэг шалгалтыг зохих ёсоор хийгээгүй	-	60 хоног түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(f) Үзлэг шалгалт хийх эрхтэй ажилтан үзлэг шалгалтын бүртгэлийг хөтлөөгүй	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх
(g) Гэрчилгээгүй этгээд техник үйлчилгээ хийх	Дундаас Дээд	-
(h) Гэрчилгээний эрх, хязгаарлалтыг хэтрүүлэн техник үйлчилгээ хийх	-	15 - 60 хоног түдгэлзүүлэх
(i) Зохих ёсоор ашиглалтад шилжүүлээгүй	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
(j) Техник үйлчилгээний бүртгэл хийгээгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх



III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(к) Гүйцэтгэсэн ажлын тодорхойлолтыг үнэн зөв гаргаагүй	-	15 - 30 хоног түдгэлзүүлэх
(l) Техник үйлчилгээний бүртгэлийг хуурамчаар үйлдэх	-	хүчингүй болгох
<b>4. Сурагч-нисгэгчийн үйл ажиллагаа</b>		
(a) Зорчигч тээвэрлэх	-	хүчингүй болгох
(b) Зөвшөөрөлгүйгээр бие даасан нислэг үйлдэх	-	45 - 90 хоног түдгэлзүүлэх
(c) Олон улсын нислэгийн үйл ажиллагаанд оролцох	-	60 - 90 хоног түдгэлзүүлэх
(d) Агаарын хөлгийг бизнесийн зорилгоор ашиглах	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
(e) Хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа гүйцэтгэх	-	хүчингүй болгох
<b>5. Үнэмлэх, зэрэглэл, зөвшөөрөл олгодог багш</b>		
(a) Сурагч-нисгэгчийн үнэмлэх, зэрэглэл, эрх, эсхүл бүртгэлийг хуурамчаар үйлдэх	-	хүчингүй болгох
(b) Нислэгийн цагийн, эсхүл бусад сургалтын цагийн хязгаарлалтыг хэтрүүлэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(c) Өөрт нь эрх олгогдоогүй агаарын хөлгөөр нислэгийн зааварчилгаа өгөх, эсхүл сургалт зохион байгуулах	-	60 - 180 хоног түдгэлзүүлэх
<b>6. Үйл ажиллагааны зөрчил</b>		
(a) Хүчинтэй НТЧ-ын, эсхүл бүртгэлийн гэрчилгээгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(b) Нислэгийн төлөвлөгөөг хаагаагүй, эсхүл нисэн ирснээ мэдэгдээгүй	Захиргааны арга хэмжээнээс Доод	-
(c) Хүчинтэй нисгэгчийн үнэмлэхгүй (үнэмлэх олгогдоогүй) нислэгийн үйл ажиллагаанд оролцох	Дээд	-
(d) Түдгэлзүүлсэн нисгэгчийн үнэмлэхтэй нислэгийн үйл ажиллагаанд оролцох	-	нэн даруй хүчингүй болгох

III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(e) Нисгэгчийн үнэмлэх, эсхүл ЭМГ биедээ авч явалгүй нислэгийн үйл ажиллагаанд оролцох	Доод	-
(f) Хүчинтэй ЭМГ-гүй, эсхүл ЭМГ олгогдоогүй байхад нислэгийн үйл ажиллагаанд оролцох	-	хүчингүй болгох
(g) Коммерийн нисгэгчийн үнэмлэхгүйгээр хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаанд оролцох	-	90 хоног түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(h) Маягийн, эсхүл ангиллын зэрэглэлгүй нислэгийн үйл ажиллагаанд оролцох	-	60 - 120 хоног түдгэлзүүлэх
(i) ЭМГ-ний тусгай нөхцөлийг мөрдөөгүй	-	90 хоног түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(j) Хөдөлмөрийн чадвараа алдсанаа мэдсээр байж үйл ажиллагаанд оролцох	-	90 хоног түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгох
(k) Нислэгийн өмнөх мэдээлэл аваагүй	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(l) НХУ-ын зөвшөөрөл, эсхүл зааварчилгаанаас хазайх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(m) НХУ ажиллаж байх үед зөвшөөрөлгүйгээр явгалах, хөөрөх, эсхүл буулт үйлдэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(n) Аэродромын хөдөлгөөний бүсэд радио холбоо бариагүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(o) Аэродромын хөдөлгөөний схемийг мөрдөөгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(p) Ойртолтын удирдлагын бүсэд зөвшөөрөлгүй, эсхүл зөвшөөрлийг зөрчиж нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх	-	60 - 90 хоног түдгэлзүүлэх
(q) Аэродромын хөдөлгөөний бүсэд тогтоосон түвшинг бариагүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(r) Хөдөлгөөний бүсэд хурдны хязгаарлалтыг хэтрүүлэх	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(s) НТЧ-гүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх	-	30 - 180 хоног түдгэлзүүлэх
(t) НТЧ-ын Удирдамжийг биелүүлээгүй	-	30 - 180 хоног түдгэлзүүлэх

III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(u) Шаардлагатай хэрэглэл / төхөөрөмжгүй нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(v) Үйл ажиллагааны эрх, хязгаарлалтыг хэтрүүлэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(w) Хязгаарлалттай бүс, эсхүл цэргийн үйл ажиллагааны бүс, эсхүл радио нэвтрүүлэг шаардлагатай зоон болон зөвшөөрөл шаардлагатай А, С, D-ангиллын хяналттай агаарын зайд НХУ-ын зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа гүйцэтгэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(x) Хөдөлгөөний давуу эрхийн дүрмийг баримтлаагүй	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(y) VFR-ийн аяллын нислэгийн түвшин хадгалаагүй	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(z) Байгууламж, хүн, эсхүл тээврийн хэрэгсэл дээгүүр шаардлагатай минимум өндрийг бариагүй		
(i) Шигүү суурьшлын бүс	-	60 - 180 хоног түдгэлзүүлэх
(ii) Сийрэг хүн амтай бүс	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
(aa) IFR-ийн нислэгийн үед радио холбоог тогтмол сонсож хянаагүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(bb) IFR нислэгийн үед тогтоосон илтгэх цэгт илтгээгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(cc) Мөргөлдөхөөс сэргийлэх гэрлээ асаагаагүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(dd) Алтиметрийн тохируулгыг зөв хийгээгүй	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(ee) Цаг агаарын үйл ажиллагаа:		
(i) Хяналттай агаарын зайд VFR минима-г дагаж мөрдөөгүй	-	60 - 180 хоног түдгэлзүүлэх
(ii) Хяналттай агаарын зайн гадна VFR минима-г дагаж мөрдөөгүй	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
(iii) Хяналттай агаарын зайд үүлнээс зай барих шаардлагыг биелүүлээгүй	-	60 - 180 хоног түдгэлзүүлэх
(iv) Хяналттай агаарын зайн гадна үүлнээс зай барих шаардлагыг биелүүлээгүй	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх

III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(ff) IFR-ийн буултын минимал-г мөрдөөгүй	-	45 - 180 хоног түдгэлзүүлэх
(gg) Хэрэглэлийн ойртолтын журмыг мөрдөөгүй	-	45 - 180 хоног түдгэлзүүлэх
(hh) Хүйтэн хөндий, эсхүл хайхрамжгүй үйл ажиллагаа:		
(i) Түлшний буруу зохицуулалт хийх /түлшгүй болох	-	30 - 150 хоног түдгэлзүүлэх
(ii) Дугуй хураалттай буулт үйлдэх	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(iii) Хэт ойр, эсхүл урт буулт үйлдэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(iv) Хаалттай ХБЗ-д буулт, эсхүл хөөрөлт үйлдэх	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(v) Апрон, эсхүл бусад зориулалтын бус талбайгаас буулт, эсхүл хөөрөлт үйлдэх	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
(vi) Явгалах үед мөргөлдөх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(vii) Хөдөлгүүр нь асаалттай агаарын хөлгийг хараа хяналтгүй орхих	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(viii) Мэргэшсэн этгээд удирдлага дээр байхгүй байхад агаарын хөлгийн сэнс эргүүлэх	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(ix) Агаарын хөлгөөс зөвшөөрөлгүй эд зүйл хаях	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(x) Агаарын хөлгийг зөвшөөрөлгүй чирэх	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(xi) Минимум өндрөөс доогуур, шигүү суурьшлын бүс дээгүүр агаарын замаар аэробатикийн нислэг үйлдэх	-	90 - 180 хоног түдгэлзүүлэх
(xii) Хангалтгүй түлштэйгээр хөөрөлт үйлдэх	-	30 - 150 хоног түдгэлзүүлэх
(xiii) Мөргөлдөх аюулын шалтгаан болохоор үйл ажиллагаа гүйцэтгэх	-	60 - 180 хоног түдгэлзүүлэх
(xiv) ХБЗ, явгалах зам, эсхүл апроноос гадуур явгалах	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх

III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>(ii) Зорчигчийн үйл ажиллагаа</b>		
(i) Хөөрөлт, нислэгийн болон буулт үйлдэх үед агаарын хөлгийн бүхээгт байгаа зорчигч бүрд байх шаардлагатай зөвшөөрөгдсөн суудал болон аюулгүйн бүсгүйгээр үйл ажиллагаа гүйцэтгэх	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(ii) Эмийн бодис, эсхүл согтууруулах ундааны нөлөөнд байгаа зорчигчийг тээвэрлэх	-	60 - 120 хоног түдгэлзүүлэх
(iii) Бүх зорчигчийг зөвшөөрөгдсөн шүхрээр хангаагүй байхдаа аэробатикийн нислэг үйлдэх	-	60 - 90 хоног түдгэлзүүлэх
(iv) Зөвшөөрөгдөөгүй шүхэр ашиглах	-	30 - 60 хоног түдгэлзүүлэх
(v) Зөвшөөрөлгүй шүхрийн үсрэлт хийх боломж олгох	-	30 - 90 хоног түдгэлзүүлэх
(vi) Ур чадварын шаардлага хангахгүйгээр зорчигч тээвэрлэх	-	30 - 120 хоног түдгэлзүүлэх
<b>7. Таних пайзтай холбоотой зөрчил</b>		
(a) Бүтээгдэхүүн дээрх таних мэдээллийг буруу арилгах, өөрчлөх, эсхүл байрлуулах		
(i) Санаандгүй	Доод	
(ii) Санаатайгаар бүтээгдэхүүний таних тэмдгийг буруу тайлбарлах	Дээд	хүчингүй болгох
(b) Таних пайзыг буруу салгах, эсхүл суурилуулах		
(i) Санаандгүй	Доод	
(ii) Санаатайгаар бүтээгдэхүүний таних тэмдгийг буруу тайлбарлах	Дээд	хүчингүй болгох
<b>8. Зөвшөөрөгдсөн сургалтын байгууллага</b>		
(a) Мэдсээр байж сургалтын агаарын хөлгийг хяналттай бодисыг хууль бусаар тээвэрлэх, эсхүл бусад хууль бус үйлдэлд ашиглах	-	хүчингүй болгох
(b) Эрх бүхий байцаагчийг байгууламж, төхөөрөмж, ажилтан, бүртгэл болон гэрчилгээг шалгах үзлэг хийхэд татгалзах	Дээд	эрх бүхий байцаагч үзлэг хийх хүртэл түдгэлзүүлэхээс хүчингүй болгох хүртэл

III. Өмчлөгч, нислэгийн ажилтан, АХТҮБ болон Сургалтын байгууллагын зөрчил (агаарын тээвэрлэгчээс бусад)	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(c) Буруу сурталчилгаа хийх	Дээд	-
(d) Оюутанд буруу кредит цаг өгөх, эсхүл төгсгөх		
(i) Санаандгүй	Дундаас Дээд	-
(ii) Санаатайгаар	-	хүчингүй болгох
(e) ИНЕГ-ын авах тест, шалгалт өгөхөөс татгалзах	Дээд	эрх бүхий байцаагч тест, шалгалт авахыг зөвшөөрөх хүртэл түдгэлзүүлэхээс хүчингүй болгох хүртэл
(f) Мэргэшээгүй, эсхүл зөвшөөрөгдөөгүй сургалт, зааварчилгаа өгөх	Дундаас Дээд	-
(g) Сургалтын бүртгэлийг хөтлөөгүй, эсхүл хадгалаагүй	Дундаас Дээд	-
(h) Үйл ажиллагаа эрхлэгчийн гарын авлага, эсхүл шалгах хуудсыг сургалтын нислэгт авч яваагүй	Доод	-

**IV. Хувь хүний үйлдсэн аюулгүй байдлын болон аюулгүйн хамгаалалтын зөрчил**

IV. Хувь хүний үйлдсэн нислэгийн аюулгүй байдлын болон аюулгүйн хамгаалалтын зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>1. Бүртгэгдсэн ачаа</b>		
(a) Цэнэглээгүй галт зэвсгийг мэдүүлээгүй	Доод	-
(b) Цэнэглэсэн галт зэвсгийг мэдүүлээгүй	Дундаас Дээд	-
(c) Шатах/тэсрэх бодис	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
<b>2. Зорчигч биш этгээд: Агаарын хөлгөөр зорчих зорилгогүй</b>		
(a) Галт зэвсэг (цэнэглээгүй, цэнэглээгүй боловч сум хэрэгсэл нь авч хэрэглэх боломжтой, эсхүл цэнэглэсэн), эсхүл бусад аюултай, эсхүл үхэлд хүргэх чадвартай зэвсгийг (цахилгаан бороохой багтана) биедээ авч явах:		
(i) Аюулгүйн үзлэгийн цэгт, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Доод	-
(ii) Аюулгүйн үзлэгийн цэгт, хүндрүүлэх нөхцөлтэй бол	Дундаас Дээд	-
(iii) Үзлэгийн дараах бүсэд, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Доодоос Дунд	-
(iv) Үзлэгийн дараах бүсэд, хүндрүүлэх нөхцөлтэй бол	Дундаас Дээд	-
(b) Аюулгүйн үзлэгийн цэгт, эсхүл үзлэгийн дараах бүсэд, агаарын хөлөгт нэвтрэх зорилгогүйгээр шатах/тэсрэх бодис биедээ авч явах	Дундаас Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
(c) Хэлбэр дүрсийг нь өөрчилсөн нууц галт зэвсэг (цэнэглэсэн, эсхүл цэнэглээгүй), бусад аюултай, эсхүл үхэлд хүргэх чадвартай зэвсэг (цахилгаан бороохой багтана), эсхүл шатах/тэсрэх бодисыг аюулгүйн үзлэгийн цэгт, эсхүл үзлэгийн дараах бүсэд биедээ авч явах	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-

IV. Хувь хүний үйлдсэн нислэгийн аюулгүй байдлын болон аюулгүйн хамгаалалтын зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>3. Зорчигч: Агаарын хөлгөөр зорчих зорилготой</b>		
(a) Аюултай, эсхүл үхэлд хүргэх чадвартай зэвсгийг (галт зэвсэг болон шатах/тэсрэх бодисоос бусад гэхдээ цахилгаан бороохой, хутга мэсийг багтаасан) агаарын тээврийн үйл ажиллагааны үед нислэгт ашиглах боломжтойгоор биедээ авч явах:		
(i) Аюулгүйн үзлэгийн цэгт, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Доод	-
(ii) Аюулгүйн үзлэгийн цэгт, хүндрүүлэх нөхцөлтэй бол	Дундаас Дээд	-
(iii) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Доодоос Дунд	-
(iv) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт, хүндрүүлэх нөхцөлтэй бол	Дундаас Дээд	-
(b) Цэнэглээгүй ба сум хэрэгслийг авч хэрэглэх боломжгүй галт зэвсгийг агаарын тээврийн үйл ажиллагааны үед, нислэгт ашиглах боломжтойгоор биедээ авч явах:		
(i) Аюулгүйн үзлэгийн цэгт, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Доодоос Дунд	-
(ii) Аюулгүйн үзлэгийн цэгт, хүндрүүлэх нөхцөлтэй бол	Дээд	-
(iii) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Дунд	-
(iv) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт, хүндрүүлэх нөхцөлтэй бол	Дээд	-
(c) Цэнэглэсэн, эсхүл сум хэрэгслийг авч хэрэглэх боломжтой галт зэвсгийг агаарын тээврийн үйл ажиллагааны үед, нислэгт ашиглах боломжтойгоор биедээ авч явах:		
(i) Аюулгүйн үзлэгийн цэгт, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Дундаас Дээд	-
(ii) Аюулгүйн үзлэгийн цэгт, хүндрүүлэх нөхцөлтэй бол	Дээд	-
(iii) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Дундаас Дээд	-
(iv) Үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт, хүндрүүлэх нөхцөлтэй бол	Дээд	-



IV. Хувь хүний үйлдсэн нислэгийн аюулгүй байдлын болон аюулгүйн хамгаалалтын зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(d) Хэлбэр дүрсийг нь өөрчилсөн аюултай, эсхүл үхэлд хүргэх чадвартай зэвсгийг (галт зэвсэг болон шатах/тэсрэх бодисоос бусад гэхдээ цахилгаан бороохойг багтаасан) аюулгүйн үзлэгийн цэгт, үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлөгт биедээ авч явах	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
(e) Шатах/тэсрэх бодисыг аюулгүйн үзлэгийн цэгт, үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлгийн бүхээгт арилжааны агаарын тээврийн үйл ажиллагааны үед, нислэгт ашиглах боломжтойгоор биедээ авч явах	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
(f) Хэлбэр дүрсийг нь өөрчилсөн галт зэвсэг, эсхүл шатах/тэсрэх бодисыг аюулгүйн үзлэгийн цэгт, үзлэгийн дараах бүсэд, эсхүл агаарын хөлөгт	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
<b>4. Бусад үйлдэл</b>		
(a) Аюулгүйн үзлэг хийлгэлгүй үзлэгийн дараах бүсэд нэвтрэх, хүндрүүлэх нөхцөлгүй бол	Доод	-
(b) Аюулгүйн үзлэг хийлгэлгүй үзлэгийн дараах бүсэд нэвтрэх, хүндрүүлэх нөхцөлтэй бол бол	Дундаас Дээд	-
(c) Эрүүгийн хуулиар хориглосон гэмт хэрэг үйлдэх оролдлогын талаар хуурамч мэдээлэл өгөх, эсхүл дамжуулах.	Дээд	-
(d) Галт зэвсэг, шатах/тэсрэх бодис, эсхүл бусад аюултай, эсхүл үхэлд хүргэх чадвартай зэвсгийг (цахилгаан бороохой багтана) заналхийлэх үйлдэлд, эсхүл бусад зорилгоор ашиглах	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
(e) Эрүүгийн хуулийг зөрчих	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-

IV. Хувь хүний үйлдсэн нислэгийн аюулгүй байдлын болон аюулгүйн хамгаалалтын зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>5. Хэв журам зөрчсөн зорчигч</b>		
Хэв журам зөрчсөн зорчигч гэж агаарын хөлөг, түүний бүхээгт байгаа хүний амь нас, эрүүл мэнд, эсхүл өмч хөрөнгөд аюул учруулсан, эсхүл учруулахаар завдсан, эсхүл агаарын хөлгийн бүхээгт санаатайгаар нийтийн хэв журам зөрчсөн этгээдийг ойлгоно.		
(a) Багийн гишүүний ажил үүрэгт саад болох	Дээд	-
(b) Нисэх багийн гишүүн, эсхүл бүхээгийн ажилтанд хүч хэрэглэх, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэх	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
(c) Нисэх багийн гишүүдээс бусад этгээдэд хүч хэрэглэх, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлэх	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
(d) Агаарын хөлөг, эсхүл агаарын хөлөгт байгаа бусад этгээдийн аюулгүй байдалд бодит аюул учруулах хэлбэрээр гэмт үйлдэл хийх	Дээд хэмжээгээр торгох ба эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр эрх бүхий байгууллагад мэдэгдэх	-
(e) “Тамхи татаж болохгүй” гэрлэн тэмдэгт асаалттай үед тамхи татах	Дээд	-
(f) Агаарын хөлгийн ариун цэврийн өрөөнд тамхи татах	Дээд	-
(g) Утаа мэдрэгчийг санаатайгаар ажиллагаагүй болгох	Дээд	-
(h) “Суудлын даруулгыг бүсэл” гэрлэн тэмдэгт асаалттай үед суудлын даруулгаа хийгээгүй	Доодоос Дунд	-
(i) Явгалах, хөөрөх, эсхүл буулт үйлдэх үед аюулгүйн бүсийг зохих ёсоор бүсэлж, зөвшөөрөгдсөн суудалд суугаагүй	Доодоос Дунд	-
(j) Цахилгаан соронзон энерги дамжуулдаг зөөврийн цахилгаан хэрэгсэл ажиллуулах	Дээд	-
(k) Үйл ажиллагаа эрхлэгч үйлчлээгүй согтууруулах ундаа хэрэглэх	Дээд	-

IV. Хувь хүний үйлдсэн нислэгийн аюулгүй байдлын болон аюулгүйн хамгаалалтын зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
<b>6. Агаарын хөлгийг лазерын гэрлээр тусгасан этгээдэд авах албадлагын онцгой арга хэмжээ</b>		
(a) Хувь хүний анх удаа, санаандгүй, эсхүл бодлогогүй гаргасан нэг удаагийн зөрчил	Дунд	-
(b) Нислэгийн ажилтны үнэмлэх эзэмшдэггүй хувь хүний санаатай зөрчил	Дээд	-
(c) Нислэгийн ажилтны гэрчилгээ эзэмшигчийн санаатай зөрчил	Дээд	Хүчингүй болгох
<b>7. Хуурамчаар үйлдэх</b>		
(a) Санаатайгаар үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэл, эсхүл зөвшөөрлийг хуурамчаар үйлдэх, эсхүл залилан хийх зорилгоор бичилт хийх, өөрчлөх, эсхүл нөхөн үйлдэх	Дээд	Үндсэн үнэмлэх, гэрчилгээг хүчингүй болгох
<b>8. Бусад зүйлс</b>		
(a) Агаарын хөлгөөр хууль бус бодис тээвэрлэх	-	хүчингүй болгох
(b) Шаардлагатай үйл ажиллагаа эрхлэх гэрчилгээгүй үйл ажиллагаа гүйцэтгэх	-	60 - 120 хоног түдгэлзүүлэх
(c) Аэродромын зөвшөөрөгдсөн таних хэрэгслийг буруугаар ашиглах	Доодоос Дунд	-
(d) Үнэмлэх, эсхүл ЭМГ эзэмших хүсэлт гаргахдаа буруу мэдээлэл өгөх	-	хүсэлтийг залруулах болон мэргэшлийг тодруулах хүртэл түдгэлзүүлэх, эсхүл үнэмлэх, эсхүл ЭМГ-г хүчингүй болгох
(e) Мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ болон ЭМГ-г шалгуулахаас татгалзах	-	шалгуулах хүртэл 30 хоног түдгэлзүүлэхээс хүчингүй болгох хүртэл

**V. Агаарын хөлгийн бүртгэлийн зөрчил**

V. Агаарын хөлгийн бүртгэлийн зөрчил	Торгуулийн хэмжээ	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(a) Бүртгэлгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэх	-	нисгэгчийн үнэмлэхийг 30 - 90 хоног түдгэлзүүлэх
(b) Тохирох, хүчинтэй бүртгэлийн гэрчилгээг агаарын хөлгийн бүхээгт авч явалгүйгээр үйл ажиллагаа гүйцэтгэх	Хэрэв үйл ажиллагаа эрхлэгч нь нисгэгчээс өөр этгээд бол, Доодоос Дээд	нисгэгчийн үнэмлэхийг 30 - 90 хоног түдгэлзүүлэх
(c) Хүчингүй болгосон, эсхүл түдгэлзүүлсэн бүртгэлийн гэрчилгээг Даргад хүргүүлээгүй	Доод	Агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгох
(d) Бүртгэлтэй агаарын хөлгийг хууль бус үйл ажиллагаанд ашиглах, эсхүл ашиглахад туслах	-	тухайн агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ болон уг өмчлөгчид олгосон бусад бүх агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээг заавал хүчингүй болгох ба бүх ажилтны үнэмлэх, ЭМГ-г хүчингүй болгох

**VI. Хувь хүн болон байгууллагын зөрчил**

VI. Хувь хүн болон байгууллагын зөрчил	Торгуулийн хэмжээ (зөрчил үргэлжилсэн өдрөөр)	Үнэмлэх, гэрчилгээнд авах арга хэмжээ
(a) Түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон үнэмлэх, гэрчилгээ, эсхүл бусад зөвшөөрөл, эсхүл ЭМГ-г Даргад нэн даруй хүргүүлээгүй	Хувь хүн: Доод, Хуулийн этгээд: Дунд	-

## С Бүлэг - ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх

### 13.201. Ерөнхий зүйл

(a) Монгол Улсын ИНД-ийн дагуу үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд холбогдох ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх хүсэлтийг САА 24011/02 маягтын дагуу гаргаж, төлбөрийн баримтын хамт Даргад хүргүүлж болно.

(b) ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх зөвшөөрлийг зөвхөн Дарга олгох ба Дарга холбогдох ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь ИНД-ийн шаардлагыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

(c) Зөвхөн зайлшгүй шаардлагатай тохиолдолд, Дарга ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх зөвшөөрөл олгож болно.

### 13.203. ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх хүсэлт

(a) Дүгнэлт гаргах хугацаа алдахгүй байх зорилгоор ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх хүсэлтийг 60-аас доошгүй хоногийн өмнө Даргад гаргана.

(b) Хүсэлт нь тухайн хүсэлт гаргагчийн дараах мэдээллийг багтаана:

- (1) овог, нэр;
- (2) хаяг болон шуудангийн хаяг (хэрэв өөр бол);
- (3) утасны дугаар;
- (4) факсын дугаар (хэрэв байдаг бол);
- (5) цахим шуудангийн хаяг (хэрэв байдаг бол).

(c) ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх хүсэлтэд энэ зүйлийн (b)-ээс гадна дараах мэдээллийг хавсаргана:

- (1) ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх үндэслэл;
- (2) ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлсний дараа гүйцэтгэх үйл ажиллагааны төрлийн тодорхойлолт;
- (3) ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэхийг хүсэж байгаа хугацаа;
- (4) ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх нь нийтийн ашиг сонирхолд хэрхэн нөлөөлөх, нийтэд бүхэлдээ ямар ач холбогдолтой болох талаарх тайлбар;
- (5) ИНД-ээр тогтоосонтой дүйцэх аюулгүй байдлын түвшинг бататгасан, хүсэлт гаргагчийн санал болгосон орлох өөр аргын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- (6) ИНД-ийн тухайн шаардлагатай холбоотой хүсэлт гаргагчийн мэдэж байгаа аливаа осол, зөрчлийн мэдээллийг багтаасан, мэдэгдэж байгаа, аюулгүй байдлын анхаарал татсан аливаа асуудлыг хэрхэн хянан шийдвэрлэсэн болон хэлэлцсэн тухай баримт;
- (7) хэрэв хүсэлт гаргагч нь ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлсний дараа Монгол Улсын агаарын зайн гадна үйл ажиллагаа гүйцэтгэхийг зорьж байгаа бол, хүсэлтэд ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх нь ICAO стандарт болон зөвлөмжтэй зөрчилдөх эсэхийг тогтоосон мэдээлэл.

(d) Хэрэв хүсэлт гаргагч нь Монгол улсын иргэн биш бол тухайн хүсэлттэй холбоотой үйл ажиллагааг Монгол Улсад зохицуулах этгээдийг заасан байх ёстой.

(e) Хэрэв тухайн хүсэлтийг яаралтай шийдвэрлэх шаардлагатай бол, шалтгаан болон холбогдох нотлох баримтыг хүсэлтэд хавсаргасан байх ба Дарга хүсэлт гаргагч тухайн хүсэлтийг яаралтай шийдвэрлэх үндэслэлээ гаргаж чадаагүй гэж үзвэл, татгалзсан хариу өгч болно.

### 13.205. Хүсэлтийг хянан шийдвэрлэх

(a) Дарга холбогдох нисэхийн ажилтан, агаарын тээвэрлэгч, нисэхийн бүтээгдэхүүн болон нисэхийн үйлчилгээнд ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно.

(b) Дарга хүсэлттэй танилцаад дараах үйл ажиллагаа гүйцэтгэнэ:

- (1) 13.205-ын дагуу тухайн хүсэлт нь шаардлага хангаж байгаа эсэхийг тодорхойлно;
- (2) хэрэв хүсэлт нь 13.205-ын шаардлага хангасан бол Дарга түүний ач холбогдлыг хянан тодорхойлж, санал авах зорилгоор хүсэлтийн дэлгэрэнгүй агуулгыг ИНЕГ-ын цахим хуудсаар мэдээлж, санал ирүүлэх хугацааг заана;
- (3) хэрэв хүсэлт нь 13.205-ын шаардлага хангаагүй бол, хүсэлт гаргагч уг шаардлагыг хангах хүртэл дараагийн арга хэмжээг авахгүй болохыг Дарга мэдэгдэнэ.

(c) Дарга баримт бичгийн бүрдүүлэлтийн шаардлага хангасан бол дараах шаардлагын дагуу үнэлгээ хийнэ:

- (1) ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх нь нийтийн ашиг сонирхолд харшлах эсэхийг тодорхойлох;
- (2) хүсэлт гаргагчийн санал нь ИНД-ээр тогтоосон шаардлагатай дүйцэхүйц аюулгүй байдлын түвшинг хангаж байгаа эсэхийг тодорхойлох;
  - *Хэрэв техникийн үнэлгээ хийх нь ИНЕГ-аас санхүүгийн хувьд их хэмжээний зардал гарна гэж үзвэл, Дарга энэ үндэслэлээр ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх хүсэлтэд татгалзсан хариу өгч болно.*
- (3) хэрэв хүсэлт гаргагч нь ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэн Монгол Улсын агаарын зайн гадна үйл ажиллагаа гүйцэтгэхээр төлөвлөж байгаа бол, ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх нь холбогдох ICAO стандарт болон зөвлөмжтэй зөрчилдөх эсэхийг тодорхойлох;
- (4) тухайн хүсэлттэй холбоотой талуудын өгсөн саналд үнэлгээ хийх;
- (5) тухайн хүсэлтийг зөвшөөрсөн, эсхүл татгалзсанаас үл хамааран, ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх хүсэлттэй холбоотой аливаа нөхцөл, эсхүл хязгаарлалтын талаар зөвлөгөө өгөх.

**13.207. ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх шийдвэр**

(a) Дарга, ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх шийдвэр гаргахын өмнө, дараах нөхцөл хангагдсан бөгөөд ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх нь нислэгийн аюулгүй байдалд эрсдэл учруулахгүй болохыг бататгах үүрэгтэй:

- (1) ИНД-ийн шаардлага нь бүхэлдээ хангагдсан бөгөөд нэмэлт ажиллагаа шаардлагагүй байх; эсхүл
- (2) хүсэлт гаргагчийн хэрэгжүүлэхээр санал болгосон арга хэмжээ нь ИНД-ийн тухайн шаардлагыг хэрэгжүүлснээс илүү үр дүнтэй байх; эсхүл
- (3) тухайн нөхцөлд ИНД-д заасан шаардлага нь тохиромжгүй, эсхүл шаардлагагүй болох нь тодорхой байх; эсхүл
- (4) тухайн нөхцөлд ИНД-д заасан шаардлага нь хэрэгцээ шаардлагагүй, эсхүл тохиромжгүй болох нь гарсан үйл явдлаар нотлогдсон байх.

(b) ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх шийдвэрийг гаргахдаа Дарга дараах шаардлагыг бататгах үүрэгтэй:

- (1) Дарга тухайн хүсэлтийг зөвшөөрсөн, эсхүл татгалзсан шийдвэр гарган, үнэлгээ хийсэн дэлгэрэнгүй мэдээллийн хамт хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэж, ИНЕГ-ын цахим хуудсаар нийтэд мэдээлэх;
- (2) мэдээлэлд ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэхтэй холбоотой тогтоосон нөхцөл, хязгаарлалт болон хугацааг заах;
- (3) хэрэв тухайн хүсэлт нь онцгой нөхцөлийг зохицуулах зорилготой бол Дарга хүсэлтэд үнэлгээ хийж, шийдвэрийг аль болох хурдан гаргах;
- (4) хэрэв ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх шийдвэр нь Монгол Улсын иргэний нисэхийн ихэнх үйл ажиллагаанд нөлөөлөх бол, Дарга тухайн шийдвэрийг AIP-д хэвлэн нийтлэх.

**13.209. Шийдвэрт бусад сонирхогч талыг хамруулах**

(a) Дараах шаардлагыг хангасан тохиолдолд, Дарга бусад сонирхогч талыг ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх шийдвэрт хамруулж болно:

- (1) хэрэв Дарга ИНД-ийн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлж болно гэж тодорхойлсон бол, бусад этгээд ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх шийдвэрт хамрагдах хүсэлтээ Даргад гаргаж болно;
- (2) хүсэлтийг 13.203-ын шаардлагын дагуу гаргана;
- (3) хэрэв Дарга хүсэлт гаргагч нь ИНД-ийн тухайн шаардлагыг өөр хэлбэрээр хэрэгжүүлэх шийдвэрт хамрагдах шаардлага хангасан гэж үзвэл, өөр хэлбэрээр хэрэгжүүлэх хугацаа болон нөхцөл, хязгаарлалтыг хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

--oOo--